



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 05

Номгон

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг  
зохицуулах аймгийн зөвлөлийн ажиллах  
журмыг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Зөвлөлийн ажиллах журмыг мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, зөвлөлийн нарийн бичгийн дарга /Д.Уранчимэг/-д даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 16 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР



**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АЖЛЫГ ЗОХИЛ УУЛАХ АЙМГИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДЭРГЭД АЖИЛЛУУЛЖ БОЛНО**

**1эг. Нийтлэг үндэслэл**

1.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн /цаашид зөвлөл гэх/ зөвлөлөөс гэмт хэрэг тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн хэмжээнд зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөл, шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, албан хаагч, эрдэмтэд, мөн ахмад настан, иргэдийн төлөөлөгчийг оролцуулан байгуулж Зөвлөлийн дэргэд ажиллуулж болно.

1.3 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хурал бөгөөд хурлаар зөвлөлийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үндсэн асуудал, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт, явц, үр дүн, зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бусад тулгарагдаж буй асуудлыг тус тус хэлэлцэнэ. Зөвлөлийн гишүүдийн олонх нь хуралд оролцож байгаа бол тухайн хурлыг хүчинтэйд тооцно. Зөвлөлийн хурлыг 2 сар тутамд хийх ба хурлын тов, хэлэлцэх асуудлыг зөвлөлийн гишүүдэд 2 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

Зөвлөлийн хурлаас тогтоол, тэмдэглэл гаргах бөгөөд түүнд зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь тогтоол, тэмдэглэл, зөвлөмжийн тусгай хэвлэмэл хуудас хэрэглэж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын албан ёсны хэвлэмэл хуудас, тамгыг хэрэглэнэ.

1.5 Зөвлөл нь тусдаа бие даасан данстай байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн зарцуулалтыг зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

1.6 Зөвлөлийн гишүүдийн идэвх оролцоог харгалзан урамшуулал олгож болно. Зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын хэмжээг зөвлөл өөрөө тогтооно.



## **1.2 Зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт**

1.2.1 Зөвлөл нь зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх /орон тоонь бус/ ба зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудал аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн бүрэн эрхэд хамаарна.

1.2.2 Зөвлөлийн үйл ажиллагааг зөвлөлийн дарга удирдан зохион байгуулна. Түүний эзгүйд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн орлогч дарга үүргийг гүйцэтгэнэ.

1.2.3 Нарийн бичгийн дарга, гишүүд нь зөвлөлийн даргын гарын үсэг, тамга бүхий үнэмлэхтэй байж болно.

1.2.4 Зөвлөл нь ажлын албатай байна. Зөвлөлийн ажлын албаны үүргийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны тухайн ажил үүргийг эрхэлсэн орон тооны ажилтан гүйцэтгэж, ажлын албыг зөвлөлийн нарийн бичгийн дарга удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

1.2.5 Зөвлөлийн гишүүдэд тодорхой сум, байгууллагуудыг хариуцуулан ажиллуулж, тэдний гүйцэтгэсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр гаргуулан ажлыг нь дүгнэнэ.

## **1.3 Зөвлөлийн санхүүжилт, үйл ажиллагааны төсөв**

1.3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн төсвийн төслийг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухайн жилийн төсөвт тусган батлуулна.

1.3.2 Батлагдсан төсвийг снэ эхэнд зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн зардлын зүйл ангиар батлуулах бөгөөд санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж зөвлөлийн хуралд тайлагнана.

1.3.3 Зөвлөлөөс гарсан цэйдвэр, удирдамжийг үндэслэн мөнгөн гүйлгээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нэгдүгээр гарын үсэг, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ня-бо хоёрдугаар гарын үсэг зурна.

## **Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг**

2.1 Зөвлөл дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, нутгийн захиргааны болон шүүх, прокурор, хууль сахиулах бусад байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлыг аймгийн хэмжээнд уялдуулан зохицуулах

2.1.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдан гарсан холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих

2.1.3 Тодорхой болон шингэрлийн гэмт хэрэг тухайлбал иргэдийн амь нас, эрүүл мэндэд халдах, хүн худалдах болон хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, хар тамхи хэрэглэх, мансуурах, архи дан согтуурах, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх болон авлигын эсрэг арга хэмжээг хүчтэй болгоход бүх нийтийн хүч оролцоог нэмэгдүүлэх, түүнд анхаарлыг чиглүүлэх

2.1.4 УИХ, Засгийн газраас нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр төлөвлөгөө болон дээрх чиглэлээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

2.1.5 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам хангах ажлыг сайжруулах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санал, хүсэлтийг судалж, түүний мөрөөр зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажилд хяналт тавих, үр дүнг тайлагнах

2.1.6 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам хангахад иргэд, төрийн бус байгууллагын үүсгэл санаачлагыг дэмжиж, тэднийг энэ ажилд өргөнөөр оролцуулах, тусалцаа дэмжлэг үзүүлэх

2.1.7 Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох ажлыг зохион байгуулж, энэ талаар хууль сахуулах байгууллагуудтай хамтран дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авах

2.1.8 Нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрөөс явуулж буй бодлогыг иргэдэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах;

2.1.9 Үндэсний өв уламжлал, хүмүүнлэг ёс, зан заншлыг сэргээхтэй холбогдсон арга хэмжээ авч хэрэгжүүлэх

2.1.10 Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдний ажлыг шалган зааварлаж, чиглэл, зөвлөгөө өгөх

2.1.11 Зөвлөлөөс зохиож буй ажлын явц, үр дүнгийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийгэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах

2.1.12 Төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнийг тодорхой хугацаанд зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хэлэлцэн, цаашид авах арга хэмжээг хамтран боловсруулах

2.1.13 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах зорилгоор нийтийн болон урамшуулалт эргүүл, жижүүр ажиллуулах, хариуцлагатай эргүүлийг томоохон баяр, ёслолын өдрүүдэд гаргаж ажиллуулах

## **2.2. Зөвлөл дараах бүрэн эрхтэй**

2.2.1 Сум, баг, томоохон аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг улирал тутам гаргуулан авах

2.2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдан гарсан хууль тогтоомж, зөвлөлийн хурлын тогтоол, тэмдэглэл, албан даалгавар, зөвлөмжийн биелэлтийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид өмчийн харъяалал харгалзахгүйгээр салгах, тэдгээрийн удирдах ажилтны илтгэл, сонсголыг Зөвлөлийн хурлаар хэлэлцэж үүрэг даалгавар, чиглэл, зөвлөгөө өгөх, түүний биелэлтийг гаргуулан авч үр дүнг тооцох

2.2.3 Нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүрдүүлж зарцуулах

2.2.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд мэргэжлийн хүмүүсийг үндсэн байгууллагатай нь тохирсон цэцэг үндсэн дээр татан оролцуулах

2.2.5 Эрх хэмжээнийхээ хүрээнд хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах

2.2.6 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах ажилд зайлшгүй шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах

2.2.7 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах ажилд идэвх санаачлагатай оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах, орон нутгийн болон төрийн шагналд тодорхойлох

2.2.8 Зөвлөлийн хурлын тогтоол, тэмдэглэл, албан даалгавар, зөвлөмжийг биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан албан тушаалтны талаар холбогдох

байгууллагад нь албан ёсоор танилцуулж, хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу авах

2.2.9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг хэвлэл, мэдээллийн байгууллагад өгч, яаралтай нийтэлж, мэдээлэх, сургалчлах ажлыг зохион байгуулах

### **2.3. Ажлын албаны ажилгүний эрх, үүрэг**

2.3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хурлын товыг гишүүдэд зарлах, хэлэлцэх асуудал, түүнд холбогдох материалыг тараах, хүргүүлэх

2.3.2. Хурлын тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн даргад танилцуулж баталгаажуулах, хурлаас гарсан шийдвэр, тэмдэглэл, албан даалгавар, зөвлөмжийн төслийг боловсруулан батлуулж, холбогдох газруудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

2.3.3. Аж ахуйн нэгж, байгууллагаас хийсэн ажлын тайланг гаргуулан авч нэгтгэх, танилцуулах, зөвлөлийн ажлын тайланг боловсруулан гаргаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх

2.3.4. Зөвлөлийн тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэлэлцэх асуудлын төслийг гишүүдээс санал авсаны үндсэн дээр боловсруулан зөвлөлийн хуралд танилцуулах

2.3.5. Зөвлөл болон нутгийн захиргааны байгууллагууд, төрийн бус байгууллага, хууль хяналтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, шуурхай удирдлагаар хангах

### **2.3.6. Бусад**

## **Гурав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах сумын зөвлөл**

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах сумын зөвлөлийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар толгойлуулсан орон тооны бус зөвлөл зохицуулна.

3.2. Сумын салбар зөвлөлийн орлогч дарга нь тухайн шатны Засаг дарга, нарийн бичгийн дарга нь хэргийн төлөөлөгч байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

3.3. Сумын салбар зөвлөл нь энэхүү журмыг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн онцлогт нийцсэн журмыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан мөрдөж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам

хангахтай холбогдсон хууль тогтоомж, дээд шатны зөвлөлийн шийдвэрийг биелүүлж ажиллана.

3.4. Сумын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг тусгай сумын Засаг даргын Тамгын газар хариуцах ба зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

3.5. Сумын салбар зөвлөл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр аймгийн зөвлөлд тайлагнана.

\_\_\_\_\_ооо\_\_\_\_\_